

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.

#### Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан  
огноо:

2023.12.27

Байгууллагын нэр:

Цагдаагийн ерөнхий газар

Нэгжийн нэр:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллага

Албан тушаалтны нэр:

Эргүүлийн цагдаа жолооч

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТТ-9

Ажлын цаг:

8 цаг

Ажлын байрны албан ёсны нэршил:

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн  
байгууллагын байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Байгалийн гамшиг, гал түймэр, хүн, малын  
гоц халдварт өвчин гарсан, гэнэтийн болон  
бусад аюул тохиолдсон, нийтийн эмх  
замбараагүй байдал үүссэн, террорист  
халдлага, онц болон дайны байдал  
зарласан, онц ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн  
зэрэг зайлшгүй тохиолдолд өндөржүүлсэн  
бэлэн байдалд ажиллах.

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ.

#### Албан тушаалын зорилго:

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийг сахиулах чиглэлээр эргүүл хийх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмжийг биелүүлэх.

#### Албан тушаалын зорилт:

- Холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах.
- Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэх.
- Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Хариуцан Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулах чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэх, үр дүнг тайлагнах;</p> <p>1.2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /Авто эргүүл ажиллах код 402/-д заасны дагуу авто эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах, гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах, эд мөрийн баримтыг хамгаалах, хойшлуулшгүй ажиллагаа явуулах, хуулиар харъяалуулсан зөрчлийг шалгаж, холбогдох албан тушаалтанд шилжүүлэх;</p> <p>1.3. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, тайлан, дүн мэдээг сар, улирал, хагас бүтэн жилээр удирдлагад танилцуулах, тайлагнах;</p> <p>1.4. “Цагдаагийн байгууллагын туслах тоо бүртгэлийн заавар”-ын хэрэгжилтийг хангах, бүртгэл, тэмдэглэлийг хөтлөх;</p> <p>1.5. Байгууллагын дотоод журмыг мөрдөх, хариуцуулсан эд хөрөнгө, автомашин, техник, тусгай хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах, хадгалах.</p>	Нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдана.	Г  Г  Г  Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>2.1. Гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эмзэг цэг, объектын орчим эргүүлийн үүрэг гүйцэтгэж, үр дүнг тайлагнах;</p> <p>2.2. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд нийтийн эмх замбараагүй байдал, жагсаал цуглаан, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, байгалийн гамшиг, хүн, малын гоц халварт өвчин үүссэн, гэнэтийн бусад аюул тохиолдсон үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг сахиулах, нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад ажиллах;</p> <p>2.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээнд оролцох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн байгуулага, аж ахуй нэгж, байгууллага болон төрийн бус байгуулага,</p>	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдал хангагдаж, урьдчилан сэргийлэх ажлын үр дүн бодитой үнэлэгдэж, үйл ажиллагаа сайжирна.	Г  Г

	<p>иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгч үр дүнг тайлагнах;</p> <p>2.4.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгасанаар сураггүй алга болсон хүн, шүүхээс даалгасан хүн, тээврийн хэрэгсэл, алдуул мал, галт зэвсэг, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах;</p> <p>2.5.Эргүүл, хамгаалалт, жижүүр, шууд захирагч дарга нараас өгсөн үүргийг гүйцэтгэх;</p> <p>2.6.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /Гүйцэтгэх ажил явуулах код 307, 307.5.2/-д заасны дагуу гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээд, алдагдсан эд зүйлийг эрж олоход ач холбогдол бүхий мэдээллийг сар тутам 2 удаа илтгэх хуудас бичиж, Эрүүгийн цагдаагийн албанд шилжүүлэн шалгуулах;</p> <p>2.7.Үйл ажиллагаандаа Цагдаагийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журам, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг мөрдөх, тэдгээрийг судлах;</p> <p>2.8.Ажлын хариуцлага, сахилга ёс зүйг сахиж, өөрийнхөө мэдлэг, боловсрол, гоо зүй, бие бялдараа хөгжүүлэх, харилцааны соёл, албан үүрэг гүйцэтгэх чадвараа байнга дээшлүүлэх.</p> <p>2.9.Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаанд оролцох, олон нийтийн цагдаагийн ажилтантай хамтарч үүрэг гүйцэтгэх.</p>		<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p><b>Ажлын байрны зорилгын хүрээнд явуулах бусад үйл ажиллагаа:</b></p> <p>1.Хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээлгэсэн ажлын байрны зорилгод нийцсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.</p> <p>2.Шууд удирдах албан тушаалтнаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврын биелэлтийг хангах</p> <p>3. Албан хэрэг хөтлөлт, архивын журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах</p> <p>4.Төрийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, байгууллагын ажилтнууд болон харилцагч, үйлчлүүлэгчид иргэдтэй зөв боловсон харьцах ёс зүйн зөрчил дутагдал гаргахгүй байх</p> <p><b>Шударга ёсны шалгуурыг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар:</b></p> <p>1.Авлига, хүнд суртлаас ангид байж хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, шударга ёсыг эрхэмлэн “Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг чанд сахих;</p> <p>2.Явцуу эрх ашиг сонирхлоос татгалзаж, цагдаагийн байгууллага, албаны нийтлэг эрх ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах.</p>	<p>Ажлын байрны зорилго, зорилт хангагдаж, цагдаагийн алба хаагчийн хуулиар хүлээлсэн нийтлэг чиг үүргийн биелэлт хангагдана.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>


### III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

<b>Боловсрол</b>	Бүрэн дунд болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
<b>Мэргэжил</b>		
<b>Мэргэшил</b>	Цагдаагийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, төгссөн байх	
<b>Туршлага</b>		
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	-Албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах. -Гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах.
	Асуудал шийдвэрлэх	- Байгууллагын чиг үүргийн хэрэгжилтэд өөрийн ажил үүргийн оруулах хувь нэмэр, оролцоог ойлгодог. -Өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг.
	Багаар Ажиллах	- Өөрийн мэдлэг ур чадвар, өөрт байгаа мэдлэгийг баг хамт олонтойгоо хуваалцаж хамтран ажиллах. - Багийн хүрээнд өөрт ногдсон үүргээ гүйцэтгэх.
	Бусад	

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

<b>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:</b> Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах тасгийн дарга	
<b>Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр, тоо:</b>  Батлагдсан орон тоо	<b>Бусад харилцах субъект:</b>  <b>Шууд харилцах:</b> Хариуцсан асуудлаар бусад яам, агентлагийн албан тушаалын адил болон түүнээс доош зэрэглэлтэй албан тушаалтан.  <b>Шууд бус харилцах:</b> Төрийн бус байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага /Эдгээртэй харилцахдаа Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль тогтоомж, үйл ажиллагааны журмын холбогдох заалтыг баримтална/.

#### V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<b>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</b>  Албан тушаал: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА   Т.ГАНЗОРИГ  2023 оны 12 дугаар сарын 27 ны өдөр	<b>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</b>  Байгууллагын нэр:.....  Шийдвэрийн огноо:.....  Дугаар:.....
<b>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</b>	

Байгууллагын нэр: ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2023 оны 12 дугаар сарын 27... өдөр.

Дугаар: А/401

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Т.СҮХБОЛД

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

**Танилцсан:**

Танилцсан албан тушаалтан: .....

20... оны .... дугаар сарын ....-ны өдөр